



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 8/114

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 06 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 онд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд аймгийнхаа нийт хүн амын 76,4 хувийг Халдвар бус өвчний эрт илрүүлэг үзлэгт хамруулсан бөгөөд үзлэгээр эрсдэл өндөртэй болон үзлэгт огт хамрагдаагүй, иргэдийг Нүүдлийн явуулын үзлэгт хамруулахад хэрэглэгдэх ходоодны уян дуранг худалдан авахад шаардагдах 70,000,000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 70,000,000 (Далан сая) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3. Сумдад ажиллах хамтарсан багийн эрт илрүүлэг үзлэгийн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, удирдлага арга зүйгээр ханган мэдээ тайланг танилцуулж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Түвшинбаяр), шаардлагатай тоног төхөөрөмжийг Худалдан авах үйл ажиллагааг зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Должинсорогдог) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6712010162